



Шинжээчийн үнэлгээний тайлан

Байгууллагын нэр: ХААИС-ийн Агроэкологийн сургууль
Хөтөлбөрийн нэр: Экологи

Индекс: 052101 бакалавр

Шинжээчийн баг:

Ахлагч: Я. Гэрэлчулуун

Гишүүд: Л. Энх-Амгалан
Ш. Анармаа

2023. 01. 10

Агуулга

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Mongolian University of Life Sciences	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Экологи - Ecology	
Индекс	052101 бакалавр	
Шинжээчид	<p>Ахлагч:</p> <p>1. Ахлагч: Я.Гэрэлчулуун Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Ургамлын судалгаа, сургалт арга зүйн төвийн эрхлэгч 99291974, gerelchuluunbiology@gmail.com</p> <p>2. Ш.Анармаа Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн биологийн тэнхимийн ахлах багш 95951267, anarmaa.sh@num.edu.mn</p> <p>3.Л.Энх-Амгалан Мандах их сургуулийн Нягтлан бодох бүртгэлийн сургуулийн профессор 99112194, enkh@monicpa.mn</p>	
	Б.Оюунчимэг Магадлан итгэмжлэл хариуцсан шинжээч	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2022.11.25.	Ажлын албаны захирлын тушаалаар томилогдсон.
	2022.11.28.	Ажлын албаны захиралтай гэрээ байгуулсан.
	2022. 11.29.	Урьдчилсан үнэлгээний тайланг ажлын албаны мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.
	2022.12.14-15.	Сургууль дээр илрэл нотолгоотой танилцаж, уулзалт хийсэн.
	2022.12.06.	Шинжээчийн багийн тайланг ажлын албанд хүлээлгэн өгсөн.
	2022.12	Шинжээчийн багийн тайланг сургуульд илгээн санал авсан.
	2023.01.10.	Шинжээчийн баг тайланг эцэслэн боловсруулж, ажлын албанд хүлээлгэн өгсөн.

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Зорилго:

Биологийн олон янз байдал, тэдгээрийн амьдрах орчин, нөлөөлөх хүчин зүйлүүд, байгалийн нөхцөл, нөөцийг судлан тогтоох, даац, чадавхид тохируулан зөв зохистой ашиглахад хяналт тавих, үнэлгээ өгөх, дүгнэлт хийх, хамгаалал, менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх мэдлэг, чадвар, дадал бүхий мэргэжилтэн бэлтгэхэд оршино.

Хөтөлбөрийн хүрэх үр дүн PLOs (Program Learning Outcomes)

Экологи, байгаль хамгааллын бакалаврын суралцагч нь уг хөтөлбөрөөр суралцаад төгсөхдөө амьд байгалийн зүй тогтлыг тайлбарлах, цаг агаарын элементүүдийг хэмжих, цаг агаарын үзэгдлийг ажиглах, хөрсний мониторингийн физик, хими, биологийн үзүүлэлтүүдийг тодорхойлох, хүний үйл ажиллагааны нөлөөллийг тодорхойлох, усны физик, химийн үзүүлэлтүүдийг хэмжих, усан орчны биологийн бүтээмж нөөцийг тодорхойлох, усны хэрэглээ, ашиглалт хамгаалалтыг сайжруулах, ургамлан бүлгэмдлийн төлөв байдал, болон өөрчлөлтийг тодорхойлох, дасан зохицох онцлогийг судлах, үнэлгээ хийх, хамгаалах, амьтадын популяцийн төлөв байдлыг тогтоох, хамгааллын төлөвлөгөөг боловсруулах, шинээр болон сэргээн нутагшуулах боломжийг эрэлхийлэх, төлөвлөх, байгаль хамгааллын менежментийг хэрэгжүүлэх, мэдлэг чадвартай болно.

Хөтөлбөрийн зорилтууд PEO (Program Educational Objectives)

Зорилт 1. Биологийн олон янз байдал, тэдгээрийн амьдрах орчныг үнэлэх

Зорилт 2. Байгалийн бүрэлдэхүүн хэсгүүдийн шинж чанар, онцлог, хувьсал, өөрчлөлтийг зүй тогтол, нөхцөл нөөцийг судлан тогтоох

Зорилт 3. Экосистемийн даац, чадавхийг судлан тогтоох

Зорилт 4. Байгалийн нөөцийг зөв зохистой ашиглахад хяналт тавих, үнэлгээ өгөх

Зорилт 5. Байгаль хамгааллын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх

Зорилт 6. Менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх онол, арга зүйг эзэмшүүлэх

Хөтөлбөрийн төгсөгчийн загвар

Төгсөгч нь хөтөлбөрийн үр дүнд ерөнхий болон мэргэжлийн онолын мэдлэгтэй, хувийн болон мэргэжлийн ур чадвартай, бие даан болон багаар ажиллах чадвар эерэг хандлагатай болж бэлтгэгдэнэ.

Сургалтын төлөвлөгөөний бүтэц

- Ерөнхий суурь хичээл **40** багц цаг (32%) байна. Үүнээс **37** багц цагийг заавал судлах байдлаар, үлдсэн **3** багц цагийг санал болгож буй хичээлээс сонгон судална.
- Мэргэжлийн суурь хичээл нийт **33** багц цаг (27%) байна. Үүнээс **27** багц цагийг заавал судлах байдлаар, **6** багц цагийг санал болгож буй хичээлээс сонгон судална.
- Мэргэшүүлэх хичээл **51** багц цаг + 12 багц цаг дадлага, төгсөлтийн ажил (41%) байна. Үүнээс **45** багц цагийг заавал судлах байдлаар, **6** багц цагийг санал болгож буй хичээлээс сонгон судална. Нийт 124 цаг.

Хөтөлбөрийн Ерөнхий суурь хичээл 40 багц цагийн 70 хувь, Мэргэжлийн суурь хичээл нийт 33 багц цагийн 50 хувь, Мэргэшүүлэх хичээл 51 багц цагийн 50 хувь онол, Ерөнхий суурь хичээл 40 багц цагийн 30 хувь, Мэргэжлийн суурь хичээл нийт 33 багц цагийн 50 хувь, Мэргэшүүлэх хичээл 51 багц цагийн 50 хувь практикийн хэлбэрээр орж байна.

Хөтөлбөрт мэргэжлийн хичээл заадаг багш нарын эрдмийн зэрэг

Багшийн эрдмийн зэрэг	2018-2019	2019-2020	2020-2021	2021-2022	2022-2023
Магистр	6	6	13	14	14
Доктор	9	12	6	5	5

Хөтөлбөрийн нэг багшид ноогдох оюутны тоо

Багш, оюутны тоо	2018-2019	2019-2020	2020-2021	2021-2022	2022-2023
Багшийн тоо	17	22	17	16	18
Оюутны тоо	496	323	329	255	180
Нэг багшид ноогдох оюутны тоо	1/20	1/14	1/14	1/11	1/10

Хөтөлбөрийн онцлог:

Сургалт “Дадлагад” суурилсан

Биологийн дадлага, экологийн дадлага, үйлдвэрлэлийн дадлага - 12 багц цаг

Хичээл бүрийн 50 хувь нь дадлага цагтай

Ш. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо: /Шаардлагатай холбоотой баримт бичиг, тоо баримт, судалгааны дүн гэх мэт судалсан бодит илрэл баримтуудыг бичнэ/.

- Өөрийн үнэлгээний тайлан

- Экологи байгаль хамгаалал сургалтын хөтөлбөр
- Экологийн тэнхимийн 2021, 2020, 2019, 2018, 2017 оны тайлангууд
 - Монгол улсын аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Алсын хараа 2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, МУ-ын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Шинэ сэргэлтийн бодлого, Байгаль орчин аялал жуулчлалын яамны стратеги төлөвлөгөө зэрэг төрийн болон салбарын бодлого, хууль эрх зүйн баримтуудыг үндэслэн хөтөлбөрөө боловсруулжээ.

Онцлог зүйл: /Туршлага/

- 1999 оноос “Экологийн менежер”,
- 2004 оноос “Экологи, байгаль хамгаалал” хөтөлбөрөөр 20 удаа төгсөлт хийсэн.
- 2015 онд магадлан итгэмжлэгдсэн.
- 2022 оны 5- сарын 09 өдрийн А/160 тушаалаар хөтөлбөрийн нэрийг “Экологи” болгон шинэчилсэн.

Анхаарах асуудал:

Ажил олгогч нараас төгсөгчдийн тоон боловсруулалтын буюу статистик, мэргэжлийн англи хэлний түвшинг дээшлүүлэхэд анхаарч хүсэлт гаргасан.

Зөвлөмж: /Бодитой хэрэгжихүйц, хэмжигдэхүйц байна./

Англи хэлний хичээлийн хөтөлбөрийг хянах мэргэжлийн англи хэлийг дунд ба түүнээсдээш шатны мэдлэг чадвар олгоход анхаарах ажиллах

Шаардлага: /Шаардлагыг хэсэгчилсэн хангасан, хангаагүй үед заавал бичнэ/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо: /Шаардлагатай холбоотой баримт бичиг, тоо баримт, судалгааны дүн гэх мэт судалсан бодит илрэл баримтуудыг бичнэ/

- ХААИС, Агрэкологийн захирлын 2021 оны 05-р сарын 31-ний өдрийн А/47 тоот тушаалын хавсралт.
- Бакалаврын хөтөлбөрийг шинэчлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүн ажиллаж хөтөлбөрт хөдөлмөрийн зах зээлийн тандан судалгаа явуулсан.
- Хөтөлбөрийг хандлагын STEEP шинжилгээ, хөтөлбөрийн оролцогч талуудын санал асуулгын шинжилгээ, хөтөлбөрийн боловсролын зорилго, зорилтуудад харьцуулсан шинжилгээг 2015-2022 онуудад хийж, хөтөлбөрийн суралцахуйн үр дүн, төгсөгчийн загварыг тодорхойлсон байна.

Онцлог зүйл: /Туршлага/

Хөтөлбөрийг боловсруулах, сайжруулахдаа өөрийн орны эрэлт хэрэгцээг хангахуйц экологийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх цогц чадамжийг судлан тодорхойлж, экологи, байгаль орчин боловсролын салбарт олон улсын болон улсын хэмжээнд баримталж буй өнөөгийн бодлого чиг хандлага, шаардлагад нийцүүлэхийг зорьсон.

Анхаарах асуудал:

Ахисан тувшингийн хөтөлбөрийн зорилготой залгамж холбоог сайжруулах.

Биологи хичээл 6 кредит оруулсан үүнийг тус бүрд биологи, ургамал судлал, амьтан судлал гэсэн бие даасан хичээл болгон орвол тохиромжтой.

Төгсөгчдөөс тоон боловсруулалтын буюу статистик, мэргэжлийн англи хэлний цагийг нэмэгдүүлэх хүсэлт байгааг уламжилсан.

Зөвлөмж: /Бодитой хэрэгжихүйц, хэмжигдэхүйц байна./

Төгсөгчдөөс мэргэшүүлэх чиглэлийг аль болох бага курсээс нь 1 ба 2-р курсэд чиглүүлж өгвөл суралцагсдын мэргэжлийн дадал чадвар эзэмших боломж, хугацаа нэмэгдэж байна гэсэн зөвлөмж санал хүргүүлсэн.

Шаардлага: /Шаардлагыг хэсэгчилсэн хангасан, хангаагүй үед заавал бичнэ/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо: /Шаардлагатай холбоотой баримт бичиг, тоо баримт, судалгааны дүн гэх мэт судалсан бодит илрэл баримтуудыг бичнэ/

- БСШУС-ын сайдын 2022 оны 5-сарын 09-ний өдрийн А/160 дугаар тушаал “Мэргэжлийн хөтөлбөр, чиглэл, индекс шинэчлэн батлах тухай”
- БСШУС-ын сайдын 2014 оны А/174 дүгээр тушаалаар батлагдсан “Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”, А/285 дугаар тушаал, түүний хавсралт “Бакалаврын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний ерөнхий суурь чиглэлд заавал судлах хичээлийн жагсаалт”
- “ХААИС-ийн захирлын 2015 оны А/377 дугаар тушаалаар батлагдсан “Хөтөлбөрийн хорооны журам”
- “ХААИС-ийн захирлын 2014 оны А/427 дугаар тушаалаар батлагдсан “ХААИС-ийн бакалаврын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө боловсруулах журам”, “ХААИС-ийн бакалаврын сургалтын хөтөлбөрийн загвар”

Онцлог зүйл: /Туршлага/

“Экологи” хөтөлбөрөөр суралцаж төгссөн төгсөгчид нь мэргэжлийн болон хувь хүний эзэмшвэл зохих чадамжуудыг хангалттай хэмжээнд эзэмших, хичээл заах багшийг сонгох боломжид суралцагч сэтгэл хангалуун байх, хөтөлбөрийн хичээлийн хэлбэр, онол практикийн зохистой харьцааг хадгалах, хичээл хоорондын уялдаа, залгамж холбоог хангах зэргээр мэргэжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Анхаарах асуудал:

Зөвлөмж: /Бодитой хэрэгжихүйц, хэмжигдэхүйц байна./ Хичээл заах багшийг сонгох боломжид суралцагч сэтгэл хангалуун байх, тэдний саналыг харгалзан үзэж удирдах түвшинд шийдвэрлэдэг байх. Гаргасан шийдвэрийг оюутны төлөөлөлд албан журмаар мэдэгддэг байх хэрэгтэй

Шаардлага: /Шаардлагыг хэсэгчилсэн хангасан, үед заавал бичнэ/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо: /Шаардлагатай холбоотой баримт бичиг, тоо баримт, судалгааны дүн гэх мэт судалсан бодит илрэл баримтуудыг бичнэ/

- БСШУС-ын сайдын 2014 оны А/174 дүгээр тушаалаар батлагдсан “Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”, А/285 дугаар тушаал, түүний хавсралт “Бакалаврын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний ерөнхий суурь чиглэлд заавал судлах хичээлийн жагсаалт”, 2017 оны А/174 дүгээр тушаалын нэмэлт өөрчлөлт хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагын дагуу агуулгад шинэчлэл оруулсан байна.
- Экологи хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөг 2002, 2007, 2011, 2015, 2017 онуудад шинэчлэн сайжруулсан.
- 2017 оны байдлаар экологийн тэнхимд 107 хичээл буюу 276 хичээл, дадлага харъяалагдаж байсан ба үүнээс 39 хичээлийн хөтөлбөрийг шинээр, 113 хичээлийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулсан.
- ХААИС-ийн захирлын 2018 оны А/213 тоот тушаалаар экологийн тэнхимд 99 хичээл харъяалагдах болсон. Экологийн тэнхимийн хичээлүүд ЕСО-гэсэн кодтой байна.

Онцлог зүйл: /Гуршлага/

Хөтөлбөрийн чанарын шинэчлэлийн хүрээнд жил бүр ажил олгогч, төгсөгч, суралцагсдаас сэтгэл ханамжийн судалгааг авч сургалтын бодлого зохицуулалтын албанд судалгааны үр дүнг нэгтгэн, дүн шинжилгээ хийсний дүнд эрэлт хэрэгцээ, шаардлагад тулгуурлан хичээлийн агуулгын шинэчлэлийг хийдэг.

Анхаарах асуудал: Оюутууд болон төгсөгч нартай хийсэн уулзалтад сэтгэл ханамжийн судалгааны асуулгууд оновчтой биш олон жил болж байгаа гэсэн санал их ирсэн.

Зөвлөмж: /Бодитой хэрэгжихүйц, хэмжигдэхүйц байна./Суралцагчдаас авдаг сэтгэл ханамжийн судалгааны асуулгуудын тодорхой хугацаанд шинэчлэдэг байх. Асуулгыг боловсруулахдаа оюутнуудаас санал авах хэрэгтэй.

Шаардлага: /Шаардлагыг хэсэгчилсэн хангасан, хангаагүй үед заавал бичнэ/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо: /Шаардлагатай холбоотой баримт бичиг, тоо баримт, судалгааны дүн гэх мэт судалсан бодит илрэл баримтуудыг бичнэ/

- ХААИС-ийн захиралын 2020 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн А/167 тушаалын хавсралт, ХААИС-ийн цахим сургалтын журам.
- Цахим сургалтын арга: Цахим сургалтын хүрээнд хичээл удирдан явуулахдаа Google classroom, Google meet зэрэг программыг ашигладаг.
- Идэвхтэй сургалтын арга: Хөтөлбөрөөр тодорхойлсон үр дүнд хүрэхийн тулд багш бүр идэвхтэй сургалтын аргуудыг өргөн хүрээнд хэрэглэж байна. Үүнд: асуудалд суурилсан, туршилтад суурилсан, кейсд суурилсан, төсөлд суурилсан, багаар ажиллаж гэх мэт.

Онцлог зүйл: /Туршлага/

- Экологи хөтөлбөрийн хорооноос цөм хөтөлбөрийг сайжруулах, оюутнуудын болон төгсөгчдийн уулзалт, эрдэмтдийн цуврал лекц, семинар, хөтөлбөрөөр суралцагчдыг гадаад, дотоодын судалгааны ажилд оролцуулдаг.
- Сургалтын заах аргын нэгдлээс багш нарт сургалтын арга зүйн зөвлөгөө өгдөг, туршлагатай багш нараар сургалтын заах арга зүйн сургалт, семинар, видео уулзалт, зохион байгуулдаг.

Анхаарах асуудал:

Зөвлөмж: /Бодитой хэрэгжихүйц, хэмжигдэхүйц байна./

Шаардлага: /Шаардлагыг хэсэгчилсэн хангасан, хангаагүй үед заавал бичнэ/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо: /Шаардлагатай холбоотой баримт бичиг, тоо баримт, судалгааны дүн гэх мэт судалсан бодит илрэл баримтуудыг бичнэ/

- ХААИС үр дүнд суурилсан сургалтад шилжсэнтэй, холбоотойгоор хичээл бүрт өөр өөр аргаар оюутны олж авсан мэдлэг, чадварыг дүгнэхдээ стандарт, стандарт бус үнэлгээгээр үнэлж байна. Үүнд: Тохиолдолд суурилсан сургалт, сорилтод суурилсан сургалт, зориулагдсан орчинд суурилсан сургалт, туршилтад суурилсан сургалт, асуудалд суурилсан сургалт, төсөлд суурилсан сургалт гэх мэт.

- ХААИС-ийн захирлын (2016 онд) тушаалаар батлагдсан “Хичээлээр эзэмших хувь хүний ур чадвар, хандлагыг үнэлэх зөвлөмж”, “Хичээлээр эзэмших хувь хүний ур чадвар, хандлагыг үнэлэх” арга зүйн дагуу 7 шалгуур үзүүлэлтээр үнэлдэг.
- ХААИС-ийн сургалтын журмын 6-р зүйлд “Оюутны мэдлэг чадвар, хандлагыг дүгнэх” тусгасан стандарт бус үнэлгээ.

Онцлог зүйл: /Туршлага/

Ерөнхий суурьд тооцогдох зарим хичээлийг шалгалт өгч шууд тооцох журам хэрэгжүүлдэг байна.

Анхаарах асуудал:

Зөвлөмж: /Бодитой хэрэгжихүйц, хэмжигдэхүйц байна./

Шаардлага: /Шаардлагыг хэсэгчилсэн хангасан, хангаагүй үед заавал бичнэ/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо: /Шаардлагатай холбоотой баримт бичиг, тоо баримт, судалгааны дүн гэх мэт судалсан бодит илрэл баримтуудыг бичнэ/

Шалгуур үзүүлэлтүүдийн хүрээнд дараах нотлох баримтуудтай танилцлаа. Үүнд:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Хөтөлбөрийн оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа 2018-2020 оны хичээлийн жил (Агроэкологийн сургууль) – сургалтын хэрэглэгдэхүүний чанарт өгсөн үнэлгээ 1, 2-р курсын болон 3, 4-р курсын оюутнуудын сэтгэл ханамжийн судалгааны дүн
- Агроэкологийн сургуулийн экологийн тэнхимийн 2021, 2020, 2019, 2018, 2017 оны тайлангууд

Дээрх тайлан материалтай танилцсаны үүднээс дараах зүйлс ажиглагдав. Үүнд:

- Хичээлийн төв байран дахь – 321, 326, 333, 264, 151 болон эрхлэгчийн өрөө – нийт 6 өрөө буюу 146.1 м² багш нарын ажлын өрөө, 349.4 м² анги танхим байгаа бөгөөд нэг багшид ногдох нь 7.7 м², нэг оюутанд ногдох нь 6.9 м² байгаа нь шалгуур хангасан гэж үзэхүйц байна. Түүнчлэн лаборатори тус бүрээр нэг оюутанд ногдох талбайн хэмжээг бодож тусгаснаас харахад стандартаас давсан тохиолдол ажиглагдсангүй.
- 2021 оны тэнхимийн тайланд сургалтын орчныг шинэчлэх ажлын хүрээнд нэг анги, хоёр лаборатори засвар хийгдэж, нэг лаборатори шинээр нээгдсэн байна. Түүнчлэн шинээр лабораторийн материаллаг баазыг шинэчлэн 24 суурин компьютер, 4 канон-принтер, 4

проектор, 6 нөүтбүүкийг шинээр авсан байна. 2019 онд 7 анги танхимыг тохижуулсан байна. Мөн 2018 онд 2 анги танхимыг засан сайжруулсан байна.

- Түүнчлэн олон нийт, иргэний барилгын БНБД 31-03-03 стандартад хичээлийн орчин нийцэж байв.

Түүнчлэн шинжээч газар дээр ажиллах явцад дараах зүйлсийг ажиглав. Үүнд:

- Оюутанд зориулсан төрөл бүрийн үйлчилгээний төвүүд байдаг тухай дурдагдсан байна. Үүнд: “Оюутан зоог” цайны газар, сүүний цех, утасгүй интернэт, Хаан банк, Төрийн банк, Капитал банкны АТМ, хувцасны өлгүүр, “Хатантуул” театр зэрэг байна. Эдгээрээс “Оюутан зоог” ажиллахгүй байв. Утасгүй интернэт нь харин оюутантай хийсэн ярилцлагын явцад оюутнууд хүртээмжгүй байдаг гэдэг дээр ихэнх оюутнууд санал нийлж байв.
- Экологийн хөтөлбөрт хамааралтай нийт 12 лабораторийг дурдсан байна. Эдгээр нь хөтөлбөрт дурдагдсан хөрсний экологи, усны экологи, ургамлын экологи, ойн экологи, микробын экологи, экологийн судалгааны арга зүй, газарзүйн мэдээллийн систем, экологийн аялал жуулчлал хичээлүүдэд чиглэгдсэн байна. Лаборатори шаардлагатай хичээлүүдийн ихэнх нь сургалтын зориулалттай лабораторитой байна. Газар дээрх нотлох баримт цуглуулах үйл явцын үед лабораторийн орчинд аюулгүй ажиллах заавар, аюул ослын үед авах арга хэмжээг байрлуулсан ганцхан лаборатори байв. Оюутнуудтай ярилцсан ярилцлагаас үзэхэд лабораторийн хичээлийн хүртээмж хангалтгүй гэдэг үнэлгээтэй байна.
- Багаж хэрэгслийн тухайд гэвэл сургалтад ашиглагдах лаборатори, тоног төхөөрөмжийн жагсаалтыг дурдсан бөгөөд очиж ажиллах явцад байгаа нь нотлогдсон болно. Өөрийн үнэлгээний тайланд дурдсанаар эдгээр багаж хэрэгслүүд нь хангалттай байна. Түүнчлэн мэргэжлийн хичээлүүдийн онцлогт суурилсан лаборатори, тоног төхөөрөмжөөр хангагдсан эсэх талаарх санал асуулгыг өөрийн үнэлгээний тайлангийн Хүснэгт 3.8-д оруулж өгсөн байгаа бөгөөд хангалттай гэж үзжээ.
- Мөн суралцах өрөө танхим болон бие даах кабинетаар хангагдсан эсэх талаарх санал асуулгыг өөрийн үнэлгээний тайлангийн Хүснэгт 3.8-д оруулж өгсөн байна. Тэгэхэд хангалттай гэсэн хариулт авсан байна. Гэвч ярилцлагын явцад ямар нэг шалтгааны улмаас аль нэг ангид хичээл орох боломжгүй болох тохиолдолд оюутнууд хичээлдээ суухын тулд хичээл орох боломжтой хоосон анги, танхим хайдаг байдал ажиглагдав.

Онцлог зүйл: /Туршлага/

Практик туршлагад тулгуурласан сургалтыг түлхүү оруулах үүднээс хичээлийн хөтөлбөрт тохирохуйц сургалтын олон лабораторитой нь уг хөтөлбөрийн давуу тал болж байна. Мөн анги танхимын шинэчлэлт, лабораторийн шинэчлэлтийг багш нар бие даан болон нэгдсэн байдлаар санаачилгатайгаар жил бүр зохион байгуулж явуулж ирсэн байна.

Анхаарах асуудал:

- Сургалтын хэрэглэгдэхүүний болон анги танхимын бодит хангамжийг сайжруулах тал дээр илүүтэй анхаарч оюутан, багш нараас авах санал асуумжийг илүүтэй нарийвчлах, санал асуулгыг авахдаа залхаах олон асуулттайгаар биш тодорхой асуудалд чиглэсэн байдлаар түүврийн байдалтайгаар авч, чиглэсэн арга хэмжээ авч болохуйц байхаар асуултыг тусгахад анхаарах.
- Түүнчлэн интернэт орчин гэх мэт оюутны суралцах орчныг дэмжих үйл ажиллагааг аль болох тухайн хэрэглэгчдэд хүртээмжтэй байдлыг сайжруулах тал дээр анхаарах хэрэгтэй байна.

- Багшийн ажиллах орчин хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх талаар зөвхөн өрөө, танхимын хангамжийн талаар л тайланд дурдагдсан байв. Өрөө тасалгааны дулаан, хүйтний хувьд ажиллахад тохиромжтой орчин бүрдсэн эсэх талаарх мэдээлэл бас хомс байв. Мөн ажиллах орчинд шаардагдах бусад хэрэгслүүдээр хангагдсан эсэх талаар лавлан асуухад багш нарт тодорхой хэмжээнд цаас, бичгийн хэрэгсэл гэх мэт зүйлсээр хангадаг гэсэн боловч энэ талаар өөрийн үнэлгээний тайланд дурдагдсан зүйл байхгүй, ер нь тайлангуудад дурдагдсан зүйл байхгүй бөгөөд хэдий хэр зардал энд зарцуулагддаг нь тодорхой бус байв. Хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх тал дээр багшийн ажиллах орчин нь хэрхэн нөлөөлж байгааг цаашид анхаарч суурь мэдээлэл цуглуулж, цаашид хэрхэн хөгжүүлэх тал дээр төлөвлөн ажиллах нь зүйтэй болов уу.
- Оюутнууд дадлагын баазын талаарх асуудал хөндсөн бөгөөд энэ асуудал нь өөрийн үнэлгээний тайланд тусгагдаагүй бөгөөд ямар нэг байдлаар нотлох баримт хангалттай биш байсан тул зөвхөн анхаарах асуудалд оруулж үлдээв.

Зөвлөмж: /Бодитой хэрэгжихүйц, хэмжигдэхүйц байна./

Хэдийгээр сургалтын орчны хувьд суурь шаардлагуудыг хангасан байгаа боловч илүүтэй сайжруулж болохуйц харагдаж байгаа дээр зарим нэг зөвлөмжийг дурдвал:

- Багшийн ажиллах орчин, материаллаг баазын талаарх судалгааг хийх.
- Сургалтын тоног төхөөрөмж, урвалж бодис, мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим орчны ашиглалт, хүртээмж, сэтгэл ханамжийн чиглэсэн судалгааг илүү нарийвчилж, түүврийн байдлаар оюутнуудаас авах.

Шаардлага: /Шаардлагыг хэсэгчилсэн хангасан, хангаагүй үед заавал бичнэ/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/ Хэсэгчлэн хангасан/ Хангаагүй

Шалгуур нь сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх (1) шаардлага хангасан, (2) стандартад нийцсэн, (3) шинэчлэл хийдэг байна гэж заасны дагуу авч үзэхэд сургалтын анги тэнхим, лаборатори, өрөө, багаж хэрэгсэл нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тохиромжтой, стандартад нийцсэн бөгөөд аль болохоор шинэчлэлийг төлөвлөн гүйцэтгэдэг бөгөөд хөтөлбөрийн зорилготой уялдуулан анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчныг сайжруулах системийг бүрдүүлсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо: /Шаардлагатай холбоотой баримт бичиг, тоо баримт, судалгааны дүн гэх мэт судалсан бодит илрэл баримтуудыг бичнэ/

Шалгуур үзүүлэлтүүдийн хүрээнд дараах нотлох баримтуудтай танилцлаа. Үүнд:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Хөтөлбөрийн оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа 2018-2020 оны хичээлийн жил (Агроэкологийн сургууль) – сургалтын хэрэглэгдэхүүний чанарт өгсөн үнэлгээ 1, 2-р курсын болон 3, 4-р курсын оюутнуудын сэтгэл ханамжийн судалгааны дүн

- Агроэкологийн сургуулийн экологийн тэнхимийн 2021, 2020, 2019, 2018, 2017 оны тайлангууд
- Хичээлүүдийн үзүүлэн материал хавтас

Дээрх тайлан материалтай танилцсаны үүднээс дараах зүйлс ажиглагдав. Үүнд:

- Сургуулийн дотоод болон төслийн санхүүжилтээр сургалтын лабораторийн тохижилт, тоноглолыг хийсэн байна. Түүнчлэн шинээр судалгааны, сургалтын лабораторийг байгуулсан байна.
- Биет үзүүлэн, хэвлэмэл үзүүлэн гэх мэт хэрэглэгдэхүүнийг тохирох байдлаар бэлдэж ашигладаг аж. 2019 оны болон 2018 оны тэнхимийн тайланд багш нарын хийж боловсруулсан электрон материал, хичээлийн иж бүрдлийг тусгаж өгсөн байна.
- Сургалтын хэрэглэгдэхүүний чанарт өгсөн үнэлгээг оруулж өгсөн байна. Хэрэглэгдэхүүний чанарт хамрагдсан асуултад нь
 - Видео үзүүлэн, бусад тараах материал ашигладаг эсэх
 - Хичээлийн материалыг интернэтэд байршуулдаг эсэх
 - Багшийн лекцийн болон дадлага илтгэл нь хэр зэрэг ойлгомжтой эсэх
 - Багшийн хичээлд хэрэглэж байгаа сурах бичгийн чанар
 - Багшийн лекцийн хичээлийн бэлтгэлийн талаарх зэрэг нэлээдгүй нарийн асуултуудыг оруулж өгсөн байна.
- Хичээлүүд дээр аль болох сүүлийн үеийн программ хангамжаар хангахаар ажилладаг бөгөөд. Жишээ нь газарзүйн мэдээллийн системийн хичээл дээр ArcGIS программ хангамжийг ашигладаг бөгөөд программ хангамжийн хувьд өөрийн үнэлгээний тайлан болон оюутнуудтай хийх ярилцлагаас үзэхэд хангалттай байдаг байна.

Түүнчлэн шинжээч газар дээр ажиллах явцад дараах зүйлсийг ажиглав. Үүнд:

- Лабораториуд нь тодорхой хэмжээнд мэргэжлийн багаж хэрэгслээр хангалттай тоноглогдсон байв.
- Хичээлийн материалуудыг оюутнуудад хүртээмжтэй байлгах тал дээр сайтар анхаарч ажилладаг бөгөөд энэ нь ч бас ярилцлагуудын явцад нотлогдов.
- Лабораториудад дадлага хичээлд ашиглагддаг гэх урвалж бодисуудыг өрж тавьсан байв.

Онцлог зүйл: /Туршлага/

Сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмжтэй байдалд ач холбогдол өгч багш нар энэ талаараа нэлээдгүй ажилласан бөгөөд оюутнуудаасаа мөн энэ талаарх нарийвчилсан сэтгэл ханамжийн судалгаа авч үнэлж дүгнэдэг юм байна. Орчин үед онлайн сургалт явагдах болсонтой холбоотойгоор биет үзүүлэн, материалуудыг цахим болгоход анхаарч ажиллажээ.

Анхаарах асуудал:

Сургалтад хэрэглэгдээд зарцуулагдаад өнгөрдөг материаллаг зүйлс, бодис, урвалжийн хүрэлцээний талаарх баримт өөрийн үнэлгээний тайлан болон бусад ер дурдагдаагүй бөгөөд энэ нь хүртээмжтэй эсэх талаарх санал асуулга зэрэг ямар нэг асуумж судалгаа байхгүй байв. Ажиглалтын үеэр лабораторид байгааг ажигласан боловч аман ярилцлагын үед оюутнууд хүртээмжгүй байдаг талаарх сэтгэгдлээ хуваалцсан.

Зөвлөмж: /Бодитой хэрэгжихүйц, хэмжигдэхүйц байна./

Хэдийгээр сургалтын хэрэглэгдэхүүний хувьд суурь шаардлагуудыг хангасан байгаа боловч илүүтэй сайжруулж болохуйц харагдаж байгаа дээр зарим нэг зөвлөмжийг дурдвал:

- Аль болох лиценз шаардагдахгүй программ хангамж ашиглах боломжийг эрэлхийлэх. Жишээ нь QGIS гэх мэт.

- Хичээлд зарцуулагддаг бодис, урвалжийн хүртээмжийн талаарх судалгаа багш нар болон оюутнуудаас авч тусгах

Шаардлага: /Шаардлагыг хэсэгчилсэн хангасан, хангаагүй үед заавал бичнэ/

Дадлага хичээлд зайлшгүй шаардлагатай лабораторийн нэг удаагийн хэрэгсэл, бодис, урвалжууд нь зайлшгүй шаардлагатай материаллаг нөөц гэдэгтээ орох бөгөөд эдгээрийн хангамж, хүрэлцээний талаарх судалгаа, баримт байхгүй байгааг бүрдүүлэх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/ Хэсэгчлэн хангасан/ Хангаагүй

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны (1) программ хангамж, (2) хичээлийн хэрэгсэл, (3) материаллаг нөөцөөр хангадаг байна гэсэн шалгуурын хувьд программ хангамж, хичээлийн хэрэгслээр хангах асуудлыг анхааран төлөвлөж, ханган ажилладаг бөгөөд энэ талаарх үйл явцаа тасралтгүй сайжруулах тогтолцоо бүрдүүлж, оюутан суралцагч нараасаа санал асуулга авч өөрийн үнэлгээ дээрээ тулгуурлан байнга сайжруулалт хийгддэг байна. Харин материаллаг нөөцийн талаарх төлөвлөлт, хэрэгжүүлэлт, түүнийгээ үнэлэх тогтолцоо байгаа эсэх дээр нотлох баримт хангалтгүй байгаа тул хэсэгчлэн хангасан байна гэж үзэж байна.

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо: /Шаардлагатай холбоотой баримт бичиг, тоо баримт, судалгааны дүн гэх мэт судалсан бодит илрэл баримтуудыг бичнэ/

Шалгуур үзүүлэлтүүдийн хүрээнд дараах нотлох баримтуудтай танилцлаа. Үүнд:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Хөтөлбөрийн оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа 2018-2020 оны хичээлийн жил (Агроэкологийн сургууль) – сургалтын хэрэглэгдэхүүний чанарт өгсөн үнэлгээ 1, 2-р курсийн болон 3, 4-р курсийн оюутнуудын сэтгэл ханамжийн судалгааны дүн

Дээрх тайлан материалтай танилцсаны үүднээс дараах зүйлс ажиглагдав. Үүнд:

- Уламжлалт сэдэвчилсэн номын сангууд болон цахим номын сангийн үйлчилгээг нэвтрүүлж буй дэвшилтэт алхмыг нэвтрүүлж буй. Үүнтэй холбоотойгоор үндсэн эрэлт ихтэй биет номуудыг цахимжуулах ажил хийгдэж байгаа.
- Цахимжуулах ажлын хүрээнд эрдэм шинжилгээний 1000 гаруй бүтээлийн хураангуйг сканердан, цахим каталогтой холбон өгчээ.
- Нээлттэй, чөлөөт уншлагын танхимуудыг нээж ажиллуулж байгаа.
- Олон улсын хэд хэдэн цахим санг ашиглах эрхтэй болсон байна
- Мэргэжлийн ном, сурах бичгийн хангамж, шинэчлэлтийн талаарх санал асуулга багш, оюутнуудын дунд явуулж уг судалгаан дээрээ үндэслэн сайжруулах, баяжуулах ажлыг зохион байгуулдаг нь бас нэмэгдэж буй ном сурах бичгийн тоо, зарцуулагдсан хөрөнгө, нэг оюутанд ногдох номын тооноос харагдаж байв.
- 2020-2021 онд суралцаж буй 127 оюутнуудын авсан судалгаагаар сургуулийн номын сангийн хүрэлцээ хангамжийн талаарх, тэр дундаа уншлагын танхимын хүрэлцээ хангамж, үйлчилгээ, нөхцөл, сурах бичгийн хүрэлцээ, хангамжийн талаарх асуултуудад 64.4% нь маш сайн, сайн гэж үнэлжээ.

Түүнчлэн шинжээч газар дээр ажиллах явцад дараах зүйлсийг ажиглав. Үүнд:

- Номын сан саяхан шинэ байрандаа нүүж ороод тохижилтоо хийж дуусгахаар ажиллаж байгаа боловч оюутнууддаа үйлчлэхээр уншлагын танхимуудаа нээсэн байв.
- Номын санг тухтай, чөлөөтэй үйлчлүүлэхэд анхаарч хувцасны шүүгээ, хүлээлгийн танхим зэргийг бэлдэж эхэлсэн байв.
- Ном сурах бичиг, хэрэгцээт мэдээллийн үүсвэрээр хангахын тулд номын сангийн катологийг цахимжуулсан бөгөөд хаанаас ч уг катологийг ашиглах боломжтой байлгах ажилласан байна.
- Мэргэжлийн ном сурах бичгийг төв номын санд байрлуулахаас гадна өөрсдийн сургууль дээрээ оюутнуудад хүртээмжтэй байлгах үүднээс бичил номын буланг сургууль дээрээ ажиллуулж байв.

Онцлог зүйл: /Туршлага/

Мэргэжлийн ном сурах бичгийг төв номын санд байрлуулахаас гадна өөрсдийн сургууль дээрээ оюутнуудад хүртээмжтэй байлгах үүднээс бичил номын буланг сургууль дээрээ ажиллуулж байв.

Анхаарах асуудал:

Сүүлийн таван жилд худалдан авсан ном, сурах бичгийн тоо жилээс жилд буурч, зарцуулсан хөрөнгийн хэмжээ багассан байв.

Зөвлөмж: /Бодитой хэрэгжихүйц, хэмжигдэхүйц байна./

Сүүлийн таван жилд худалдан авсан ном, сурах бичгийн тоо жилээс жилд буурч, зарцуулсан хөрөнгийн хэмжээ багассан байгаа нь эрэлт хэрэгцээ буурснаас уу, эсвэл мэргэжлийн сайн ном, сурах бичиг хангалттай зах зээлд нийлүүлэгдэхгүй байгаагаас болов уу эсвэл өөр дотоод шалтгаан байна уу гэдгийг цааш нь мөшгөн судалж үзэх

Шаардлага: /Шаардлагыг хэсэгчилсэн хангасан, хангаагүй үед заавал бичнэ/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/ Хэсэгчлэн хангасан/ Хангаагүй

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт (1) ном (2) сурах бичиг, (3) мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангах шаардлагыг бүрэн хангасан байна.

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө, 2021 – 2030 он
- ХААИС-ийн хөгжлийн стратеги төлөвлөгөө (2028 он хүртэл)
- Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө, 2021 – 2030 он
- ХААИС-ийн хөгжлийн стратеги төлөвлөгөө (2028 он хүртэл)
- ХААИС-ийн хөтөлбөрийн хорооны журам, ХААИС-ийн захирлын 2015 оны А/377 дугаар тушаал
- Багшийн ур чадварын судалгаа, 2018 – 2019 оны хичээлийн жил, 2019 – 2020 оны хичээлийн жил
- Оюутны сэтгэл ханамжийн судалгаа, 2018 – 2019 оны хичээлийн жил, 2019 – 2020 оны хичээлийн жил
- Төгсөгчийн сэтгэл ханамжийн судалгаа, 2018 – 2019 оны хичээлийн жил, 2019 – 2020 оны хичээлийн жил
- Ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгаа, 2018 – 2019 оны хичээлийн жил, 2019 – 2020 оны хичээлийн жил
- ХААИС-ийн Агроэкологийн сургуулийн Экологийн тэнхимийн ажлын тайлан, 2017, 2018, 2019, 2020, 2021 он

Онцлог зүйл:

- Хөтөлбөр нь ХААИС-ийн Сургалтын бодлого, зохицуулалтын албанаас гаргасан дүрэм, журмын хүрээнд хэрэгждэг. Хөтөлбөрийн чанарыг сайжруулахын тулд үе шаттайгаар төлөвлөгөө гаргасан.
- Экологи хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа ХААИС-ийн хөтөлбөрийн ерөнхий хороо, Агроэкологийн сургуулийн хөтөлбөрийн хороо, Экологи хөтөлбөрийн хороогоор дамжин явагддаг.
- Экологи хөтөлбөрийн хорооноос цөм хөтөлбөрийг сайжруулах, оюутнуудын болон төгсөгчдийн уулзалт, эрдэмтдийн цуврал лекц, семинар, хөтөлбөрөөр суралцагчдыг гадаад, дотоодын судалгааны ажилд оролцуулах зэрэг ажлыг хийсэн байна.
- Төгсөгч, ажил олгогч, сонирхогч талын төлөөллөөс санал авч хөтөлбөрийн зорилго, зорилтуудыг тэдний эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн сайжруулж байна.
- Тус хөтөлбөрөөр төгсөгчид ажил олгогчдын шаардлагад нийцэж байгаа талаар болон ажил эрхлэлтийн байнгын судалгаа хийж, төгсөгчдийг ажлын байраар хангах тодорхой бодлого, үйл ажиллагааг явуулж байна.

Анхаарах асуудал:

Зөвлөмж:

Шаардлага: /Шаардлагыг хэсэгчилсэн хангасан, хангаагүй үед заавал бичнэ/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн гэрээ, ажлын тайлан /Өөрийн үнэлгээний тайлангийн Хүснэгт 4.4, 4.5, 4.6 – д үзүүлснийг илрэл нотолгооны тайлангаар үзэв/
- Тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын судалгаа, 2018 – 2020 он
- Дотоодын судалгаа, арга хэмжээнд оролцсон ажлын тайлан /Өөрийн үнэлгээний тайлангийн Хүснэгт 4.7 – д үзүүлснийг илрэл нотолгооны тайлангаар үзэв/
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны мэдээлэл, 2018 – 2022 он

Онцлог зүйл:

- Хамтран хэрэгжүүлсэн судалгаа, байгуулсан гэрээ, багш, оюутан солилцооны тоо нэмэгдсэн байна. Сүүлийн 5 жилд 16 хамтарсан төсөл, хөтөлбөрийг гадаад 9 улсын байгууллагуудтай хэрэгжүүлж, давхардсан тоогоор 61 багш, 33 оюутан оролцсон байна.
- Олон улсын хурал, семинарт давхардсан тоогоор 41 багш, 3 оюутан оролцож, 19 илтгэл хэлэлцүүлэн, төслийн 4 тайлан хүлээлгэн өгчээ. Дотоодын 27 арга хэмжээнд давхардсан тоогоор 55 багш, 100 гаруй оюутан оролцож, 32 илтгэл хэлэлцүүлжээ.

Анхаарах асуудал:

Зөвлөмж:

- Мэргэжлийн холбоод, ТББ-тай холбоо тогтоон хамтран ажиллах талаар анхаарах.
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагаанд анхаарах.

Шаардлага: /Шаардлагыг хэсэгчилсэн хангасан, хангаагүй үед заавал бичнэ/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС-ийн санхүүгийн үйл ажиллагааны журам, 2015 он
- АОС-ийн жилийн төсөв, зарцуулалтын тайлан, 2016-2021 он
- Экологи хөтөлбөрийн нэг оюутанд ногдох зардлын судалгаа, 2016-2021 он
- Сургалтын төлбөрөөс хөтөлбөрт зарцуулагддаг хувь хэмжээ, үр дүнгийн судалгаа, 2018 – 2021 он

Онцлог зүйл:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг их сургуулийн стратеги төлөвлөгөө, жил бүрийн төсөвт тусган, оюутны холбоо, бүрэлдэхүүн сургууль, тэнхимийн түвшинд зарцуулах зардлыг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган баталгаажуулдаг байна.

Анхаарах асуудал:

Зөвлөмж:

- Сургалтын төлбөрийн орлогын тодорхой хувийг хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагааг сайжруулахад зориулах

Шаардлага: /Шаардлагыг хэсэгчилсэн хангасан, хангаагүй үед заавал бичнэ/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС-ийн маркетингийн идэвхжүүлэлтийн хөтөлбөр, ХААИС-ийн захирлын 2015 оны 3 дугаар сарын 3-ны А/61 тоот тушаал
- Хөтөлбөр сурталчлах ажлын тайлан, мэдээлэл, 2016 – 2021 он

Онцлог зүйл:

- Хөтөлбөрийн сурталчилгааг “ХААИС-ийн маркетингийн идэвхжүүлэлтийн хөтөлбөр”-ийн дагуу явуулж байна.
- ЕБС-ийн сурагчдын дунд мэргэжил сурталчлах уулзалт, өдөрлөг зохион байгуулахаас гадна сургууль болон мэргэжлийн сургалтын үйл ажиллагаатай танилцуулах ажлыг зохион байгуулдаг.

Анхаарах асуудал:

Зөвлөмж:

Экологи хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөг сайжруулж, хэрэгжилтийг ханган ажиллах

Шаардлага: /Шаардлагыг хэсэгчилсэн хангасан, хангаагүй үед заавал бичнэ/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС-ийн Мэдээллийн систем - ISLS
- Хөтөлбөрийн талаарх сурталчилгааны товхимлууд
- ХААИС-ийн вебсайт – <https://www.muls.edu.mn>

Онцлог зүйл:

- Хөтөлбөрийн удирдлагын шуурхай, оновчтой үйл ажиллагааг хангахад чиглэсэн мэдээлэл цуглуулах, боловсруулах удирдлагын мэдээллийн тогтолцоотой.
- Оюутны бүртгэл, хичээл сонголт, хичээлийн хуваарь, дүн, диплом хэвлэх зэрэг элсэлтээс төгсөлт хүртэлх сургалтын бүх үйл ажиллагаа ХААИС-ийн мэдээллийн систем(ISLS)-ээр дамжин явагддаг байна.

Анхаарах асуудал:

Зөвлөмж:

Шаардлага: /Шаардлагыг хэсэгчилсэн хангасан, хангаагүй үед заавал бичнэ/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо: /Шаардлагатай холбоотой баримт бичиг, тоо баримт, судалгааны дүн гэх мэт судалсан бодит илрэл баримтуудыг бичнэ/

Шалгуур үзүүлэлтүүдийн хүрээнд дараах нотлох баримтуудтай танилцлаа. Үүнд:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Хөтөлбөрийн оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа 2018-2020 оны хичээлийн жил (Агроэкологийн сургууль) – сургалтын хэрэглэгдэхүүний чанарт өгсөн үнэлгээ 1, 2-р курсын болон 3, 4-р курсын оюутнуудын сэтгэл ханамжийн судалгааны дүн
- Элсэгчдэд зориулсан гарын авлага

